


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 01 ДҮГЭЭР САРЫНҮЙЛ АЖИЛЛАГААНЫТАЙЛАН

2018.01.26

Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн талаар:

Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөг сумдын ИТХ-аар батлуулснаар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж 2017 оны 12 сарын 26-ны өдрөөс эхлэн орон нутгийн “Залуус” телевизээр өнөөдрийг хүртэл зарлаж байна. Мөн байгууллагын сайт, гадуур томоохон нийт 11 үйлдвэр үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн/Андууд супермаркетуудын салбарууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, Дугуй дэлгүүр, Өгөөж зах, Өрхийн эмнэлэгүүд, Балдан засаг зах, сумын ЗДТГ, Хаан банкны АТМ, Нэг цэгийн үйлчилгээний төв, Баянтал сумын ЗДТГ гэх мэт/ үүдэнд зар наах зэргээр иргэд олон нийтэд зарлан ажилласан.

Баянтал, Сүмбэр сумын газрын даамлууд 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн өргөдөл хүлээн авч 2018 оны 1 сарын 15-ны өдрийг хүртэл Баянтал суманд 127 иргэний, Сүмбэр суманд 504 иргэний өмчлөх хүсэлтийг бүртгэн баталгаажууллаа. Үүнээс гадна төлөвлөгөөг зурган байдлаар гарган цаасаар болон самбар хэлбэрээр хэвлэн байршуулж сурталчилж ажилласан.



Төлөвлөгөөгөөр:

➤ Баянтал суманд шинээр өмчлүүлэх 127 иргэнд 26,5 га газрыг 3 байршилд

➤ Сүмбэр суманд шинээр өмчлүүлэх 504 иргэнд 39,68 га газрыг 1 байршилд өмчлүүлэх төлөвлөгөө батлагдсан. Үүнээс:

- Баянтал суманд 127 иргэн
- Сүмбэр суманд 504 иргэний хүсэлтийг хүлээн авч ЛМ програм хангамжаар бүртгэн аваад дууссан байна.

Аймаг, суманд өмчлөлийн өргөдөл авч эхэлсэнтэй холбогдуулаад 100 иргэнд газар өмчлөөгүй лавлагаагаар үйлчлэн ажилласан.

Газрын кадастр, төлбөр, татвар үнэлгээ:

- БОХ-1, БОХ-2
- СТА-1,6,7,8,9
- ГТ-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9
- Газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалсан тайлан /mle.mn сайтаас/
- СӨХ-дын газар ашиглалтын мэдээ
- Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын мэдээ, тайлан зэргийг холбогдох хаягуудаар хүргүүлэв.

Сүмбэр сумын гамгаас хамгаалах штабт малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн харуулсан зургийг А0, А1, А2 хэмжээтэй гаргаж өгсөн.

Шивээговь суманд хүрэн нүүрс олборлодог Шивээ-овоо ХК-ний 2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж үйл ажиллагаатай танилцан үнэлт, дүгнэлт өгч ажилласан. Тус байгууллага нь 2017 онд биологийн нөхөн сэргээлт хийгээгүй газар хамгаалах үйл ажиллагаа хангалтгүй байсан гэж үзэж дүгнэлт зөвлөмж өгч ажилласан.



Монгол улсын Газрын тухай хуулийн дагуу газраа зориулалтын дагуу 2 жил ашиглаагүй мөн газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 11 иргэн аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмших эрхийг хүчингүй болгох албан мэдэгдэл хүргүүлэнажилласан.

Засаг даргын албан тоот ИААНБ-д хүлээлгэн өгсөн жагсаалт						
№	ИААНБ-ын нэр	Хүлээлгэн өгсөн албан тоотын дугаар	Хүлээлгэн өгсөн огноо	Хүлээн авсан хүний нэр	Утасны дугаар	Тайлбар
1	Д.Болорчимс	17/8/2018				
2	Д.Хашаагтох	10/10/2018			89180087	
3	Ш.Насалчид	1/27/2018			99073059	
4	Дорнод ХХК - н Батбаяр	1/28/2018				
5	Говьсүмбэр аймаг Төрийн банк	1/29/2018	2018.7.14	Х.Х.Х.	99919043	
6	Д.Баттүл	1/30/2018	2018.7.14	Х.Х.Х.	80000099	ХХК
7	Б.Энхтүвшин	2018/1/32	2018.01.10	Х.Х.Х.	80000080	Б. Энхтүвшин
8	М.Жаргал	2018/1/33	2018.01.10	Х.Х.Х.	98850642	
9	Я.Оюун	2018/1/34	2018.01.10	Х.Х.Х.		Х.Оюун
10	Орхон дорнод ХХК	1/25/2018	2018.01.13	Х.Х.Х.	99047905	
11	Өндөр Буянт Холдинг ХХК	2018/1/35				

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
42010 Говьсүмбэр аймаг Шивээговь сум, Сүхбаяр
Утас: 9001 0000

2018.01.15 № 1/35
Хугацаа: _____

“ӨНДӨР БУЯНТ ХОЛДИНГ” ХХК-д


Танай байгууллага нь сумын Засаг даргын 2013 оны А/119 тоот захирамжаар тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 112 га газрыг “Агаарын шугам”-ын зориулалтаар эзэмшиж авсан билээ.

Тус газраа “Газрын тухай хууль”-ийн 40-р зүйлийн 40.1.5 дахь заалт /Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй/, 40.1.6 дахь заалт /Хүндэтгэн үзэх шалгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй/, мөн газар эзэмших гэрээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнүүлэх гэсэн заалтуудыг зөрчсөн тул газар эзэмших эрхийг хүчингүй болгож байгааг мэдэгдэж байна.

Иймд газар эзэмших гэрээ, гэрчилгээ болон холбогдох бичиг баримтыг сумын Газрын даамбалд хүлээлгэн өгнө үү.

Б. БАТ-ЭРДЭНЭ
C:\Documents\B-H\TOOT.doc
050009

Сүмбэрсум 3-р багт “Амтатзоог”-ийн газраас урагш авто замын зүүн талд зарлагдсан 1500 м² газарт 3 оролцогч оролцож иргэн Ц.Сүхбаяр хамгийн өндөр үнийн санал буюу 8,200,000 /Найман сая хоёр зуун мянган/ төгрөгийн үнийн санал ирүүлж ялагчаартодорлоо.



Барилга захиалагчийн хяналт:

Нэгдсэн эмнэлэгийн амбулаторийн засварын ажлын гүйцэтгэлийг шалгасан. Ажлын гүйцэтгэлтэй танилцаад гүйцэтгэгч компани зөвлөмжийг хүргүүлсэн хувийг НЭ,АЗДТГ хүргүүлсэн.

Мэдээ тайлан:

1. Аймгийн аудитын газарт Улсын төсвөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн мэдээг хавсаргалтын дагуу гаргаж өгөв.
2. Төрийн албан хаагчийн шилжилт хөдөлгөөний тайлан шинэчилсэн программд 11 албан хаагчийн материалыг оруулав.

Өргөдөл гомдол, хүсэлт:

1. Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн Халдвартын тасгийн барилгын дулаан алдагдлыг тодорхойлж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу газар дээр нь барилгатай танилцаж 2018 оны 01 сарын 22-ны 01/26 албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн.
2. ЭкоСүмбэр хотхоны гадна бохирын шугам бөглөрсөнтэй холбогдуулж утсаар гомдол ирсэний дагуу 2018.01.25 өдөр очиж үзэхэд гадна шугам бөглөрсөн хальсан байдалтай байсан үүний дагуу “Илчит сансар” ХХК инженертэй холбогдох бидний зүгээс боломжтой арга хэмжээг авсан боловч гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалсан дутагдал байгаа тул бүрэн засварлаж чадахгүй байна гэдэг хариу өгсөн, гүйцэтгэгч: Хүрийн хотхон ХХК захиарал Цогбадрахтай утсаар холбогдож үүсэн нөхцөл байдлын талаар мэдэгдэж яаралтай арга хэмжээ авахыг мэдэгдсэн. Яаралтай арга хэмжээ аван тоног төхөөрмжтэй нь ажилтнаа явуулъя гэдэг хариу өгсөн. Албан шаардлага өгөхөөр бэлтгэж байна.
3. 3 дугаар сургуулийн спорт залны дээврээс ус гоожсон гэх мэдэгдлийн дагуу 2018.01.15 өдөр газар дээр нь очиж шалгахад дээвэр гэмтэл байсан. Үүнийг Захиалагч байгууллага. сургууль, гэмлийн талаар мэдээлэл тухай үед нь өгсөн. Мөн гүйцэтгэгч компани Цахир толгойн орд ХХК-ний захирал Энхжаргалтай холбогдож, мэдэгдэл хүргүүлсэн, газар дээр нь ирж үзсэн шаардлагатай арга хэмжээг авъя хариу албан бичгээр хүргүүлэхээр болсон.